

Манмин Мэдээ

№ 48 2014 оны 7 сарын 6

Перугийн нэгдсэн их цуглаанаар сэргэсэн Латин Америк дахь сайн мэдээний үйлчлэл, Ном хэвлэл, нэвтрүүлэг болон эдгэрэл ивээлийн цуглаанаар дамжуулан арвин их үр жимс боловсорч байна



Зураг 1, 2: 2002 онд И Жей руг пасторын Гондурас хийсэн Нэгдсэн их цуглаан, Латин Америкт ассан үйлчлэлийн гал, Зураг 3: Перугийн Ерөнхийлөгчтэй хамт ерөнхийлөгчийн ордонд, Зураг 4, 5: И Жей руг пасторын Перу Нэгдсэн их цуглаан, Зураг 6-10: Үй олон хүмүүс төрөл бүрийн хүнд өвчнөөсөө эдгэрч, эдгээж өгсөн Бурханыг алдаршуулж буй нь Зураг 11-13: 2014 оны 4 сард И Хи сон пасторын Колумб, Перуд хийсэн “Эдгэрэл ивээлийн цуглаан.”

Солонгос улсын Сөүл хотод орших Манмин Төв сүм нь орон нутагт болон дэлхий дахинаа нийт 10000 гаруй салбар болон хамтран ажилладаг сүмтэй бөгөөд Латин Америкт ч Бурханы гайхамшигт эрх мэдэлт хүчний үйлсийг ном, хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлийг ашиглан үйлчлэлээ идэвхитэй явуулж байна.

Энэ үйл ажиллагаа нь хэдийн 1996 онд И Жей руг пастор нь Солонгосын Ивээлийн Нэгдсэн Их Цуглаан, орон нутгийн пасторуудын семинарт оролцохоор Аргентинд уригдсан ба мөн 1997 Сэргэлтийн цуглаан, семинарт дахин оролцсон юм. 2002 онд Тэрээр Гондурас, 2004 онд Перуд Нэгдсэн их цуглааныг удирдан явуулж Бурхан бол Бүтээгч, зөвхөн Есүс Христ л бидний цор ганц Аврагч юм гэдгийг нотлон харуулж маш олон тэмдэг гайхамшигийн хүч нөлөө дагалдсан юм.

Ялангуяа И Жей руг пасторын өвчтөний төлөөх залбирлаар дамжуулан үй олон хүн эдгэшгүй өвчнөөсөө эдгэрч, хорт хавдарууд бүр ДОХ өвчин ч эдгэрч, хараагүй хүмүүс хардаг болж, таягаа хаян өөрөө явдаг болж, тэргэнцэртэй хүмүүс хөл дээрээ бүрэн зогсож явж

чаддаг болон тэд бүгд Бурханд бүх алдрыг өргөж байв.

Түүнээс хойш Колумб, Перу гэх мэт Латин Америкийн өнцөг булан бүрт салбар сүм, хамтарсан сүмүүд байгуулагдаж, эдгэрэл ивээлийн цугларалтууд үргэлж хийдэг болсон юм. Түүгээр ч зогсохгүй И Жей руг пасторын сургаалуудыг Enlace TV-р испани хэлээр ярьдаг орнуудад цацдаг болсон бөгөөд Гондурасын JBN-р дамжуулан маш олон хүн Амьд Бурханы хүчит үйлсийг мэдэрч, уулзаж байгаа билээ.

Одоо И Жей руг пасторын сургаалууд албан ёсоор цацагдаж, ялангуяа ням гаригийн өглөө бүр “И Жей руг пасторын Амийн Үг” нэвтрүүлэг нь олон номлогчдын талархлыг хүлээж байгаа юм. Түүнчлэн Enlace TV-ийг үзээд ивээл авсан үзэгчид интернетээр Манмин төв сүмд бүртгэгдэн итгэлийн амьдралаар баяр хөөртэй амьдарч байгаа билээ.

Үүний зэрэгцээ И Жей руг пасторын номнууд Испани, Португал хэлээр хэвлэгдэн гарч, Бразилийн Наос, Америкийн Вида Ньюва хэвлэлийн компаниар дамжуулан тараагдсаар байгаа билээ.

2014 оны 4 сарын 3нд Перу Манмин сүмд (Хариуцагч И Жэ Ху пастор) Манмины бүх салбар сүмүүдийн удирдагч И Хи сон пасторын удирдсан “Эдгэрэл ивээлийн цуглаан” болж өнгөрсөн юм. Уг цуглааныг И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуураар (Үйлс 19:11-12) өвчтэй хүмүүсийн төлөө залбирч өгсөн юм. Энэ цуглаанд маш олон хүн оролцсон бөгөөд ялангуяа 2004 оны “Филиппиний нэгдсэн их цуглаан”-ы бэлтгэл ажилд оролцож байсан Үа мани пастор хүрэлцэн ирсэн юм.

Энэ өдөр И Хи сон пастор нь Еврей 10:22 ишлэлээр дамжуулан “Жинхэнэ итгэл” гэдэг сургаал номлож, оролцогчид хамтдаа гэмшлийн залбирлыг өргөсөн билээ. Үүний дараа И Хи сон пасторын залбирал авахаар дараалан зогссон олон зуун өвчтэй хүнд тэрээр нэг нэгээр нь чин сэтгэлээсээ гар алчуурын залбирал хийж өгсөн. Энэ залбирлыг авахаар хэдэн сарын өмнөөс мацаг барин бэлтгэж сүмийн итгэгчид тэр дороо хариултаа авч Бурханыг алдаршуулж байлаа.

Гюллермо Диаз ахан дүү 20 жилийн

турш суусан тэргэнцэрээсээ босч өөрөө явж чаддаг болсон бол Фаннит Жанет Давилагийн эгч дүүс өндгөвчний үрвэсэлээсээ эдгэж, Бенжамин Салазар ахан дүүсийн хараа нь сайжирч, өндөр байсан цусны даралт, диабет, элэгний өвчин нь эдгэрсэн байна.

Түүнчлэн 4 сарын 5нд И Хи сон пастор нь Колумб Манмин сүмийн (Хариуцагч Жан жон оён пастор) ойн баярын үйл ажиллагаанд уригдан сургаал номлож, гар алчуурын цуглааныг (Үйлс 19:11-12) удирдсан билээ. Энэ цуглаанд Енласэ Колумбын захирал хадагтай Росалба Родригиз Де Ринсон мөн Венесуэлээс ирсэн хэдэн пасторууд оролцсон юм. И Хи сон пасторын гар алчуурын залбирлаар Диана Морено эгч дүүсийн холын хараа эдгэрч, Марикса Перез эгч дүүсийн өндгөвчний уйланхай болон арьсний хүнд хэлбэрийн харшил нь эдгэрсэн байна. Тус цуглаанд оролцсон итгэгчид энэ бүхнийг хийж байгаа Бурханд бүх алдрыг өргөж байлаа. Энэхүү гайхамшигт үйлс нь Латин Америкт Ариун Сүнсний хүч чадлаар илүү эрч хүчтэй үйлчлэх агуу их итгэл найдвар, хүчийг өгсөн юм.

Ариун байдлын мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж” (Иаков 3:17).



И Жей руг Тэргүүн пастор

юуны түрүүнд эхлээд Эзэнээс эмээн, хүндэтгэн хорон муугаас холдох хэрэгтэй билээ (Сургаалт үгс 16:6). Иаков 3:17-д үзвэл “Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж” гэж байдаг. Энд ‘дээрээс ирэгч мэргэн ухаан’ гэдэг Бурханы мэргэн ухааныг хэлж байгаа юм. Бид Бурханаас эмээж хорон муугийн бүх хэлбэрийг хаяж, ариухан цэвэр зүрх сэтгэлтэй болсоноор л Бурханаас мэргэн ухааныг маш амархан, хамгийн дөт арга замаар олж авч чадах юм.

2. Цэвэр, ариухан сэтгэлээс гарах сайн мэргэн ухаан

Зүрх сэтгэлдээ сайхан сэтгэлээр дутмаг хүмүүс хэн нэгний хорон муу санааг мэдсэний дараа сэтгэл нь нэг л эвгүй болж, гомдож, тавгүйцэж, дургүйцэх болдог. Хэдий тийм биш ч түүнтэй уулзах бүртгээ дургүйцлээ илэрхийлж, ёжтой, егөөдөн харьцаж ч болох юм. Харин сайны мэргэн ухаантай хүн бусдад дургүйцэж, бусдыг дорд үзэж, бусдыг шархлуулдаггүй харин алдаа дутагдлаа олж мэдэхэд нь тусладаг. Энэ мэт Бурханы мэргэн ухаан нь сайн арга барилаар алив асуудлыг шийддэг. Бид зүрх сэтгэлдээ сайн, сайхныг хураасны хирээр Бурхантай илүү гүн, дотно харьцаж, Бурханаас сайн мэргэн ухааныг авч чадна. Гэвч сэтгэлд атгаг хорон зүйл байх л юм бол бид сайн мэргэн ухааныг хичнээн зааж өгсөн ч амьдралдаа хэрэгжүүлэхэд маш хэцүү юм. Тиймээс зүрх сэтгэлдээ байгаа атгаг хорон бүх зүйлээ авч хаях нь Бурханы сайн мэргэн ухааныг авч, түүнийхээ ашиг шимийг хүртэнэ. Тэгвэл ухаалаг хүн нь энэ бүхнийг ойлгож Бурханы сэтгэлийг хөдөлгөх хэмжээний сайн, Бурханы тааламжит залбирлыг хийх болдог. Жишээлбэл та өөрийгөө нэг эсийн бүлгийн ахлагч гээд бод доо. Хэдийгээр та маш их хичээж байгаа ч сэргэлт удаан, бүр зарим итгэгчид таны талаар гомдол гаргаж, дургүйцэж байна гэж бодъё. Ийм нөхцөлд та Бурханд хандан таны дотор байгаа хорон мууг байхгүй болгож өгөөч гэж гуйж болно. “Бурхан Аав минь, намайг аварсанд мөн эсийн бүлгийн ахлагч байх энэ хүндтэй үүргийг өгсөнд чин сэтгэлээсээ талархаж байна! Би өөрийн эсийн бүлгийн итгэгч нартаа энэ бие сэтгэлээ зориулан үйлчлэх чадвартай байхыг хүсч байна. Бидэнд ЭЗЭНий хайр, нулимс байгаа, Түүний хайраар би үр жимсийг гаргаж чадна. Надад итгэгчдийнхээ хайр дүүрэн зөвлөгөөг баяртай зүрх сэтгэлээр хүлээн авах тэр л сэтгэлийг өгөөч. Биднийг нэгтгэж, арвин их үр жимстэй байлгаж өгөөч.” Энэ мэт зүрх сэтгэлдээ атгаг хорон

мууг агуулаагүй хүмүүс Бурхантай адил сэтгэлтэй болж гомдох, гуниглах, гутрахаас зайлсхийж чаддаг юм. Хэрэв бидний зүрх сэтгэлд хорон муугийн хэлбэр байвал үг яриан дотор маань хүртэл хорон муу, атгаг зүйлс агуулагдаж байгааг бид өөрсдөө ч мэддэггүй байна. Тиймээс бид ямар зүрх сэтгэлтэй байна вэ гэдгээ Бурханаас асууж, залбирахад хариулт нь маш хурдан эсвэл хэсэг хугацааны дараа ч ирж болно. Бурхан сайхан сэтгэлээр хийсэн залбиралд баярлаж хурдан хариулдаг. Заримдаа та өрөөл бусадтай ойлголцохгүй байгаагаасаа болоод сэтгэлээр унаж хэцүү байдаг байж болох юм. Зарим хүн таны огт хийгээгүй, хэлж яриагүй юмыг хийсэн, хэлсэн гээд байвал хэнийх нь зөв, хэнийх нь бурууг олохыг хичээхээсээ өмнө шууд Бурханы гарт шилжүүлэх нь хамаагүй дээр байдаг. Та өөрийгөө өмгөөлж хэдий их шалтаг, шалтгаан тоочно төдий чинээ худал хуурмаг цуурхал таны тухай гарах болно. Мөн та өөрийн гэм буруугүйг хэрэлдэж маргалдаад ч хамаагүй илчилсэн ч энэ бусдын буруу болж та нарын хоорондын харилцаанд эв суух нь гарцаагүй юм.

2 Тимот 2:23-т “Харин мунхаг, эелдэг бус маргаанууд нь тэмцэл мөргөлдөөн бий болгогчийг мэдэх тул тэдгээрээс тагталз” гэсэн байдаг тул тэмцэл маргаан нь эв нэгдэл хагалж, хэрүүл тэмцэл үүсгэдэг. Иймэрхүү нөхцөл байдалд таны үнэ зөв байсныг мэдэх хүртэл та чимээгүй байж, бусдыг хүлээн зөвшөөрвөл тэдний санаа сэтгэл зөөлөрч, таньд илүү ихээр итгэх болно. Тиймээс таны төсөөлж ч байгаагүй хүнд хэцүү үе ирвэл зөвхөн хэцүү бэрхшээлтэй байна гэж бодолгүйгээр үүний үр дүнд би яг юуг ойлгож ухаарах ёстой юм бол гэж бодоод Ариун Сүнснээс тусламж гуйвал магадгүй энэ бүхэн бүгд ерөөлийн суваг болон өөрчлөгдөх боломжтой. Сургаалт үгс 3:6д “Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно” гэсэн байдаг. Та өөрийн буруугүйг нотлох гэж хичээж, олон шалтгаан, тайлбар тавилгүйгээр чимээгүйхэн Бурханы хүслийг ойлгож мэдэхийг хүсвэл та өөрөө өөрийнхөө талаар маш олон зүйлийг мэдэж авах чадвартай болно. Та өөрийгөө хамгаалж тэмцэлдэхээс өмнө дутагдалтай талаа олж мэдэх болно. Та хилс хэрэгт гүтгэгдсэн ч Бурхан таныг харж байгаа учраас та амар тайван байж болно. Тэр танд бүгдийг эргүүлэн төлж өгч сүнслэгболон материаллаг ивээлийгөгнө. Энэ бол сайн мэргэн ухаан юм.

Хичнээн сайн мэргэн ухааныг сонслоо гээд сэтгэл дотор атгаг, хорон муугийн хэлбэр байсаар байвал өөрийн болгож чадахгүй. Хэрэв бид омог бардам эсвэл гомдоллох, уурлах, дургүйцэл, тавгүйтэл

дотроо байвал сорилтыг даван гарч чадаагүй учраас хорон муугийн хэлбэрийг хаяж байж сая ариуслыг олж, мэргэн ухааны үр жимсийг ургуулах болно.

3. Сайхан сэтгэлгүй мэргэн ухаан бол угтаа учиргүй

Абсалом бол Давид хааны гурав дахь хүү нь байсан. Тэр сайхан залуу бас их мэргэн ухаантай байсан. Гэвч тэр өөрөө атгаг хорон сэтгэлтэй байсан тул мэргэн ухаанаа хорон муугаар ашигласан.

Тэр эцэг нэгтэй эх ондоо ах Амноныг өөрийн охин дүүг нь хүчирхийлсэн учраас өөрийн хүмүүстэй нийлж амийг нь хөнөөсөн. Тэгээд эцэг Давидын эсрэг өш хонзон санаж, бослого гаргахаар төлөвлөж эхэлсэн. Тэр маш олон цэргүүдийг бэлдэж, хамгаалалт тавин, удаан хугацааны турш хүмүүсийн сэтгэлийг аавынхаа эсрэг болгон болгож байв. Тэр Давид хаан ард түмэндээ анхаарал тавьдаггүй, хайр халамжгүй гэж хуйвалдаан зохиож үргэлжлүүлэн хүмүүсийн сэтгэл зүрхийг хулгайлсаар байсан. Тэр ч бүү хэл Давидын зөвлөгч Ахитофелыг хүртэл өөрийн талд урвуулсан байв. Энэ бүгд маш сайн яг л түүний төлөвлөсөнөөр болж байгаа юм шиг санагдаж байсан ч эцэстээ Абсаломын бослого нуран унасан юм. Яагаад? Бурхан Абсаломын мэргэн ухааныг үгүй болгосон. Ахитофел Абсаломд ялах аргыг зааж өгсөн боловч Абсалом түүнийг нь хүлээж аваагүй харин Давидын талд ашигтай байх зөвлөгөө өгсөн Хушайгын зөвлөгөө сонсож дагасан. Абсалом маш ухаантай байсан ч Бурхан түүнийг сул дорой, шийдэмгий биш болгон шийтгэж хормын дотор л сүйрэх замыг тэр өөрөө сонгосон байна.

Ариун байдал нь сайхан сэтгэлээс л биш бол мэргэн ухаан ямар ч ашиггүй юм. Хэрэв бидэнд сайхан сэтгэл үгүй бол хичнээн сайхан үг сонсоод ч ойлгож ухаарч чадахгүй. Харин бид зүрх сэтгэлдээ сайны мэргэн ухааныг хүлээн авбал хэлэх ёстой, ёсгүй, хийх ёстой зүйл хийх ёсгүй зүйлээ сайн ялгаж чаддаг болно. Ингэж чадвал бидний үг яриа, үйлс бүхнийг Бурхан баглан харуулж, Бурханы хариулт, ивээл, ерөөлөөр дүүрч, үр жимсийг арвин ихээр ургуулах болно. Хайрт итгэлийн ахан дүүс нар минь, хэдийгээр биднийг гай зовлонд унагаж, бүтэлгүйтэлд хүргэдэг хүмүүсийг хүртэл хайрлаж чадвал Бурхан бидэнд агуу ивээл ерөөлийг үүрд мөнх өгөх болно. Тиймээс би Эзэний нэрээр та бүхнийг Бурханд таалагдсан, үзэсгэлэнтэй сайхан сэтгэлтэй болж гэр бүл, ажлын газар гээд хаа байгаа газартаа бусдад сайны мэргэн ухаанаар аз жаргал, баяр баяслыг бэлэглэсэн нэгэн болохыг хүсэн гуйж байна.

Энэ дэлхийд хорон муу, болоод овжин сэргэлэн хүмүүс нь илүү ололт амжилттай, сайн, сайхан амьдарч байгаа юм шиг харагдах үе байдаг. Гэвч харамсалтай нь тэдний амьдрал руу нь өнгийн харвал гэр бүл, бизнес, ажлын талбар, өвчин гэх мэт асар их бэрхшээл, хүнд асуудлаар дүүрэн байдаг ба тэсвэрлэхийн аргагүй гэнэтийн асуудалд байнга өртөж байдаг.

Харин үүний эсрэгээрээ зүрх сэтгэлдээ ариун байдлыг бий болгож, мэргэн ухааныг олсон хүн нь Бурханы хайр ивээлээр дүүрэн, үргэлж хөгжин цэцэглэж, амьдардаг. Тэгвэл тэр Бурханаас өгөгддөг сайхан сэтгэлийн, мөн ариун байдлын мэргэн ухаан гэж чухам юу юм бол?

1. Бурханаас мэргэн ухааныг авах дөт зам

Юуны түрүүнд мэдлэг ба мэргэн ухаан хоёр юугаараа ялгаатай байдаг вэ? Дөнгөж сая төрсөн нялх хүүхэд нь ямар ч мэдлэг байдаггүй яг л цэвэрхэн цав цагаан цаас шиг байдаг. Тэгээд өсөж том болох тусам л юу харж, юу сонсож, юу мэдэрч байгаа бүхнээсээ суралцдаг. Үүнийг бид “мэдлэг” гэж нэрлэдэг. Харин ингэж харж, сонсож сурсан бүх мэдлэгээ зүй зохистойгоор сайн ашиглан түүнийгээ хэрэглээ болгохыг “мэргэн ухаан” гэж нэрлэдэг юм.

Тэгэхээр ‘мэргэн ухаан’ нь сайн мууг ялгах чадвар, тунгаан бодох чадвар, туршлага, ухаарал, ухаалаг байдлыг хэлдэг юм. Тэр тусмаа Бурханаас өгөгддөг мэргэн ухаан бол зайлшгүй амжилттай амьдарч, олон хүнийг авралын замд замчилж, Бурханы хаанчлалын төлөө зүтгэж, амьдралын бүх хайр энэрэл, хүндлэл дотор байх болно. Тэгвэл бид яаж Бурханаас ийм сайхан мэргэн ухааныг авах вэ? Сургаалт үгс 9:10-т “ЭЗЭНээс эмээхүй нь мэргэн ухааны эхлэл мөн. Ариун Нэгэнийг таньж мэдэх нь оюун ухаан мөн...” гэсэн байдаг тул мэргэн ухааныг авахын тулд

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Энэ дэлхий ертөнц эхлээд ямар байсан бэ?

Дэлхийн гадаргууны гуравны хоёр нь усаар бүрхэж, нарны аймаг, гариг эрхэсийн дунд зөвхөн дэлхийд л далай тэнгис байдаг. Тэгвэл энэ далай тэнгис яаж бий болсон ба анх бүтээгдэхдээ дэлхий чухам хэлбэртэй байсан юм бол?

Эхлэл 1-р бүлэгт Бурхан тэнгэр орон, газар дэлхийг хэрхэн яаж бүтээсэн тухай дүрслэн тайлбарласан байдаг. Эхлэл 1:2-г уншвал “Газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон, гүний гадаргуу дээгүүр нь харанхуй бүрхэж, Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа” гэж энэ дэлхий эхлээд ямар байсныг маш нарийн тайлбарлан бичсэн байдаг.



Газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй байв

Бүтээгч Бурхан энэ дэлхийг анх бүтээж эхлэхэд дэлхийн гадаргуу, агаар мандал өнөөдрийнх шиг байсангүй. Дэлхийн тектоник давхарга, гадаргуу, галт уулын дэлбэрэлт гэх мэт геологийн өөрчлөлтүүд идэвхитэй бий болсон бөгөөд мөн бүх төрлийн цогц үйл ажиллагаанууд агаар мандалд бүрэлдэн бий болж байв.

Эрдэмтэд эрт дээр үед дэлхийн агаар мандалд маш олон төрлийн химийн урвал явагдаж байсан, дэлхийн гадаргуу маш идэвхитэй хөдөлсөн гэж таамагладаг. Тэд маш их хүчтэй тэсрэлтийн дараа манай дэлхий үүсэж бий болсон гэж ярьдаг. Яг үнэндээ бол энэ нь тэр их тэсрэлт биш харин Бурхан дэлхий ертөнцийг бүтээсэн юм. Энэ бол Бурхан дэлхийн суурийг тавьж эхэлсэн бөгөөд агаар мандалд маш олон төрлийн хувирал явагдаж байсан (Иов 38:4;

Еврей 1:10). Ингэж дэлхийд газар, тэнгэр хоёулаа бий болж, хүн төрлөхтөнд жинхэнэ зохистой, шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн.

Тэгвэл бүхнийг чадагч Бурхан анхнаасаа л энэ дэлхийг төгс төгөлдөр бүтээлгүй дэлхийн суурийг тавих үйл явцыг дамжсан юм бол?

Хүн байшинг хүртэл барихдаа суурь тавьж үүн дээрээ яс мод зангидан хийдэг шиг Сүнс болох Бурхан ч гэсэн бодит ертөнцийн дэг журмыг даган дэлхийн суурийг тавьж бүтээсэн юм. Ингэж агуу Бурхан маань дэлхийг бүтээхдээ суурь тавьсан нь хүмүүст, хүн төрлөхтөнд ямар их хайртайгаа илэрхийлэх нэгэн арга зам байлаа.

Та өөртөө нэг байшин барих гэж байна гээд төсөөлж үзэхдээ тэр байшинд таны хамгийн

хайртай гэр бүлийнхэн урт удаан хугацаагаар амьдрах тул энэ бүхнийг тооцож, яаралгүй маш няхуур, бүх зүйлийг маш сайн тооцоолж, гэр бүлийн гишүүн нэг бүрийн шинж чанарыг бодолцсон, нөр их хөдөлмөр зарцуулж байшингаа барихдаа маш их аз жаргалтай байх болно.

Энэ мэтчилэн бүтээгч Бурхан энэ дэлхийг бүтээхдээ яг л ийм хайрын зүрх сэтгэлээр, урт удаан цаг хугацааны турш төлөвлөн бүтээсэн юм. Учир нь энэ газар дээр Бурханы жинхэнэ хүүхэд болж дасгалжуулагдах үй олон сүнснүүд амьдрах учраас тэр юм шүү дээ. Тийм ч учраас Бурхан Аав, Ариун Хүү, Ариун Сүнс гурвуулаа чин сэтгэлээсээ дэлхийн суурийг урт удаан хугацаанд тавьж хүмүүс амьдархад маш тохиромжтой орчин бүрдүүлсэн.

“Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа”

Бүтээгч Бурханы Сүнс хожим хүн төрлөхтөнийг боловсруулах талбар болох дэлхий даяар элин халин зургаан өдрийн турш бүтээхдээ дэлхийд чухал шаардлагатай зүйлс нь юу болох, хэрхэн бүрэлдэн тогтох талаар ажиглан байлаа. Түүнчлэн “Бурхан Сүнс усны мандал дээгүүр элин хальж явж байсан” гэдэг ишлэлээс бид тухайн үед дэлхий тэр чигээрээ усаар хучигдсан байсныг мэдэж болно. Бурхан удаан хугацааны туршид дэлхийн суурийг тавьсаны дараа усаар хучсан билээ.

Тэгвэл тэр их ус хаанаас гарч ирсэн юм бол? Энэ бол бүтээгч Бурханы сэнтийнээс урсан гарах амийн ус байсан юм. Эхлэл 1:9-г уншвал “Бурхан, тэнгэрийн доорх ус нэг дор хуримтлагдаж, хуурай газар ил гараг! хэмээсэнд тэр нь ёсоор болжээ” мөн 2 Петр 3:5д “Бурханы үгээр тэнгэр нь өнө эрт оршин тогтносон бөгөөд газар нь уснаас гараад усаар хэлбэржсэн болохыг тэд санаатайгаар үл ойшоодог” гэсэн байдаг. Дэлхий усан дор, байсан харин дараа нь уснаас гарч ирсэн гэдэг нь маш тодорхой байна.

Тэгвэл Бурхан яагаад дэлхийг яг эхийн хэвлий дотор хүүхэд усан дотор байдаг шиг тэр чигээр нь усаар бүрхсэн юм бол?

Энэ нь хожим хүн төрлөхтөн төдийгүй бүх амьд амьтан бүтээгдэж, энэ дэлхийд амьдрах орчныг нь бий болгохын төлөө юм. Хайрын Бурханы сэнтийнээс урсан гарах амийн ус нь

дэлхий рүү буун ирж, амьтай бүхэн амьдарч болохуйц хамгийн чухал орчин нөхцөлийг бүтээсэн юм.

Энэ дэлхийг харвал яг эхийн хэвлийд бүрэлдэж буй жаахан хүүхэд усаар хамгаалагдаж байдагтай адил амийн усаар энэ дэлхийг бүрхсэн байна. Ингэж усаар хамгаалагдсан нялх хүүхэд шиг халуун дулааны хэм хамгийн тохиромжтой нөхцөлд, үргэлж хяналтанд байж, янз бүрийн гадны халдлага, аюул, өвчингөөс хамгаалагддаг. Мөн тэгээд ч зогсохгүй эхийн хэвлийд байх хүүхэд бүх амин дэм, хэрэгцээтэй бүхнээ эхээсээ бүрэн хангагдан тэжээгддэг. Тэгээд цаг нь болохоор энэ дэлхийд мэндэлдэг.

Яг үүнтэй адил дэлхий амийн усаар бүрхэгдсэн байх үедээ бүх амь биет амьдархад маш тохиромжтой орчин нөхцөлтэй бүтээгджээ. Энэ юу гэсэн үг вэ гэвэл бүх амьд биет хүн хүртэл усгүйгээр амьдарч чадахгүй гэсэн үг. Энэ ус бол Бурханаас өгсөн ус юм. Тиймээс хүн төрлөхтөн Бурханаас салангад амьдарч хэзээ ч чадахгүй, тийм үндэслэл ердөө ч байхгүй гэдгийг бид маш сайн ойлгох хэргтэй. Яг үнэндээ Бурхан бүх хүнийг аврагдаж, мөнх амийг аваасай гэж чин сэтгэлээсээ хүссэн учраас амийн усаар дэлхийг бүрхсэн байна.

Өөр бас нэгэн чухал зүйл бол энэхүү амийн ус нь маш цэвэр тунгалаг, ариун юм. Тиймээс Бүхнийг Бүтээгч Бурханы хүсэл нь хүн төрлөхтөн сайн боловсорч, хөгжин, бүрэн дасгалжуулагдсанаар энэхүү амийн ус шиг цэвэр ариун зүрх сэтгэлтэй болохыг хүсэж байдаг юм. Тэр биднийг яг энэ амийн ус адил

гэм нүгэлгүй, өө сэвгүй, ямар ч толбогүй зүрх сэтгэлтэй Бурханы жинхэнэ хүүхэд болоосой гэж хүссэн. Махан биеийн ертөнцөд бол усаар хир буртаг, бохир зүйлсийг угаах цэвэрлэдэг. Харин Бурханы үг бол сүнслэг ус бөгөөд бид Эзэн дотор сүнсний амийг хүлээн авахын тулд элдэв бохир гэм нүглээ хаяхад нэн чухал хэрэгсэл болдог.

Бүтээгч Бурхан яаж бүхэлдээ амийн усаар хучаастай дэлхийн суурийг өнөө үеийн шиг болгосон бэ?

Эхлэл 1:3-с хойш харвал Бурхан тэнгэр, газрыг тэдгээр орших бүх зүйлийг 6 өдрийн турш хэрхэн бүтээсэн үйл явцыг нэг бүрчлэн тэмдэглэсэн байдаг.

Ялангуяа бүтээлийн хоёр дахь өдөр уг дэлхийг бүрхэж байсан усан дотор огторгуйг өөрөөр хэлбэл тэнгэрийг бий болгон огторгуйн дээрх ус, огторгуйн доорх ус хэмээн усыг уснаас салгасан (Эхлэл 1:6-8). Мөн тухайн үед дэлхийн гадаргуу дээр өндөрлөг газар юмуу уул байхгүй байсан тул бүтээлийн гурав дахь өдөр дэлхийн туйлыг бий болгон туйлаас эхлэн усыг хуримтлуулж эхлэн хуримтлагдсан усыг “далай” гэж нэрлээд, хуурай газрыг нь “эх газар” гэж нэрлэв (Эхлэл 1:9-10).

Үүний дараа бүтээлийн дөрөв дэх өдөр нь Бурхан нар, сар, ододыг бүтээж, хуурай газраа тив болгон хувааж, дэлхийн гадаргууг хөдөлгөж далайг хэд хэдэн хэсэг болгосон. Ингэж л өнөөдрийн энэ дэлхий маань хэлбэр дүрсээ олж, одоогийн байгаа төрхөөрөө харагдах болсон байна (Эхлэл 1:14-19).

“Сүнс сэтгэл сайжрах ерөөл хүртснээр бүх зүйл бүтэмжтэй сайхан болсон!”

Би бүр жаахан байхаасаа л сүмд явж эхэлсэн боловч Библид бичигдсэн ямар ч тэмдэгт гайхамшгыг хэзээ ч харж байгаагүй. Мөн амьд оршигч Бурханыг ер мэдэрч байсангүй зүгээр л Эзэний Өдөр өглөөний мөргөлд оролцчихоод ширээний теннис, билльярд, япон даам, Солонгосын хөзөр тоглон зугаацдаг байлаа. Гэхдээ би аврал авсан гэж бодоод л явдаг байсан.

Гэтэл долоон жилийн турш ‘бохирдлын өвчин’-р өвдөж байсан манай хадам үеэл (Пак Хун ги ахлагч) маань 1997 оны 5 сард Манмин төв сүмийн хоёр долоо хоногийн Эдгэрэл ивээлийн онцгой цуглаанд хамрагдаж И Жей руг пасторын залбирлыг аваад маш цэвэрхэн эдгэрсэн гэж дуулсан юм.

2002 онд би, манай гэр бүлийнхэн маань Бурхан бол амьд оршигч юм байна гэдгийг баттай итгэж Манмин Төв Сүмд итгэлийн амьдралаар амьдарч эхэлсэн. Тухайн үед ээж маань 10-д жилийн өмнөөс нуруугаа гэмтээсний улмаас бүр нурууных нь яс товойгоод гарчихсан маш их өвдөж, шаналдаг байсан юм. Гэтэл И Жей руг пасторын залбирлыг аваад л 15 минутын дараа товойж гарсан яс нь хөдөлж хэвийн болж өвчин хөндүүргүй болж эдгэрсэн юм.

Ээжийг минь эдгээж өгсөн Бурханы ивээл ерөөлд үнэхээр их баярлаж, хамгийн дуртай байсан энэ тоглоом, зугаа цэнгэлээ шууд хаян, бүх мөргөл, залбиралд оролцож эхэлсэн. Бурханы үгийг сонсохыг маш их хүсэн тэмүүлж, ивээл авч болох бүх газарт оролцож, хариуцсан үүрэг албаа сайн хийхийг хичээн зүтгэдэг болсон.

Тэгээд манай гэр бүлийнхэн миний дээрэнгүй, захирангуй зан чанар, хандлагаас болоод хэцүү байдаг юм байна гэдгийг Бурханы үгнээс ухаарч, өөрийгөө олж харсан. Хүүхдүүд маань намайг сонсохгүй, дуулгаваргүй байвал би галзууртлаа уурлаж, эхнэрээ ч гэсэн өөрийн эрхшээлд байлгахыг хичээдэг байлаа. Харин Тэргүүн пастор маань жаахан хүүхдүүдийг ч, сүмийнхээ итгэгчдийг үргэлж өөрийнхөө амьдралаас илүү үнэ цэнэтэйд тооцож, бусдын төлөө бүх хүч чадлаараа залбирч байгааг би харж их ивээл авсан юм.

Би Тэргүүн пасторыг дуурайж, өөрийгөө

өөрчилье гэж бодоод эхнэр, хүүхдүүдэдээ үйлчилж эхэлсэн. Хүүхдүүд маань залбирахгүй, бүлээвтэр итгэлтэй байсан ч тэднийг хүчлэхгүй харин залбирахад нь туслдаг байлаа. Тэр үед бид



Гу Пёон со ахлагч

(59 настай Кюнгин Татварын Корпарацийн төлөөлөгч) эхнэр И Хёон суг халамжлагчын хамт

Инчонд амьдардаг байсан тул Манмин төв сүмд Сөөлд ирэхэд тэдэнд хэцүү байсан болохоор Оройн Даниел залбиралд бид хамтдаа гэр ойрхон байдаг сүмд очих эсвэл гэртээ интернэтээр эсвэл GCN TV-р орж залбирдаг байлаа.

2010 онд баяр хөөртэйгээр Библи уншиж, И Жей руг Тэргүүн пасторын Хайрын Бүлэг, Найман ерөөл, Ариун Сүнсний есөн үр жимс гэх мэт сургаалуудыг сонсож эхэлсэн. Сургаалаас ойлгож, ухаарах тусам чин сэтгэлээсээ залбирч эхнэр, хүүхдүүд маань ч Бурханы үг, залбирлаар өөрчлөгдөхийг хичээн зүтгэж байлаа. Ингээд эцэст нь манай гэр бүлийнхэн бүгдээрээ сүнслэг сэтгэлийг олж аваад, цаашлаад Тэнгэрийн орон Шинэ Иерусалимыг зорин гүйх итгэлийн энэхүү уралдаанд эргэж буцалтгүйгээр оролцсон билээ.

Одоо манай охин Гу Хи сон номлогч нь 21-р тойргийн хариуцагч, хүү Гу гёонхи ахан дүүс Хармони багт, эхнэр И Хёон суг халамжлагч нь залбирлын эсийн

бүлгийн ахлагч, би 2-р эрэгтэйчүүдийн бүлгийн дэд ахлагчаар үйлчилж байгаа. Бурханы өгсөн эрхэм үүргийг нандигнан, ямагт эхэнд тавьсанаар ажил, бизнес маань ивээл ерөөлөөр дүүрч нийгэм өндөр байр суурь эзлэн олонд танигдсан билээ.

2003 оны 1-р сард би үндэсний татварын газарт ажилд орсноос хойш 11 жилийн турш ашиг орлого маань тогтмол өссөөр удирдлагууддаа хичээнгүй, чадвартай хүн гэж сайшаагдаж, үндэсний татварын газраас, Санхүү Эдийн Засгийн Бодлого Зохицуулалтын Яам, Ерөнхий Сайдаас тус тус шагнал хүртэж Бурханд алдрыг өргөсөн.

Одоо би Хойд Инчоно татвар, нягтлан бодогчдийн холбооны ерөнхийлөгч, Хойд Инчоно Татварын Хорооны гишүүн, Солонгосын үл хөдлөх хөрөнгийн нийгэмлэгийн лекторын ажлыг хийж байгаа. Сүнсийг минь өсгөж, энэ бүх гэрчлэлийг надад өгсөн Бурханд бүх алдар, магтаал, талархал, хүндэтгэлийг өргөж байна.



“Одоо хэвийн явж чаддаг болсондоо баярлаж байна!”



Анжелика Осорио эгч дүүс, 16 настай, Колумб Манмин Сүм

Би тулгуур ясны дутагдалтай төрсөн. Нэг настай байхдаа гуяны яснаас хэсгийг аваад өөр хэсэгт тааруулах мэс засалд орж, 10 нас хүртлээ хөлөндөө 90 градусын гипстэй байсан болохоор сургуульд ч орж чадахгүй гэртээ хэвтрийн дэглэмтэй байдаг байв.

Нэгэн өдөр ээж маань Enlace ТВ-р И Жей руг пасторын эрх мэдэлт хүчний тухай мэдээд хэрэв надад итгэл байвал эдгэрч чадах юм байна гэж хэлсэн. Эхлээд би огтхон ч итгэж чадахгүй байсан ч харин манай гэр бүлийнхэн бүгд Колумб Манмин сүмд бүртгэгдсэнээс хойш маш их өөрчлөгдсөн юм.

И Жей руг пасторын гэрчлэлийг сонсоод надаас илүү их хүнд өвчтэй, маш их шаналж байсан ч Бурхан түүнийг бүрэн эдгээсэн гэж сонсоод надад маш их баяр хөөр, итгэл найдвар төрж, урам авсан. Тэгээд би эдгэрч болох юм байна итгээд залбирч эхэлсэн билээ.

2014 оны 4 сарын 5, бнд Жан Жон ёон пасторын удирддаг Колумб Манмин Сүмийн 2 жилийн ойн мөргөл болсон юм. Манмины бүх салбар сүмүүдийн удирдагч И Хи сон пасторын удирдсан “Эдгэрэл ивээлийн цуглаан”-д (Үйлс 19:11-12) оролцож, сургаалыг нь сонсоод би Бурханд чин сэтгэлээсээ итгэдэггүй бас хүмүүсийг их үзэн яддаг юм байна гэдгээ мэдээд гэмшсэн юм. Түүний дараа И Хи сон пасторын залбирлыг авсаны дараа миний нурууны яс тэгширч ямар ч өвчин зовиургүй болсон юм. Халлелүяа!

Миний нурууны муруйж бөгтөр болсон яс, бас хөл маань тэгширч, доголж явдаг байсанаа хэвийн явдаг болсон юм. Би залбирлыг минь сонсож, эдгээж өгсөн Бурхандаа бүх алдар, магтаал, талархалыг өргөж байна.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөөл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин